



**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧНИЙ ҮНДЭСНИЙ ТӨВ
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2017 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дэх хэсэг, Эрчим хүчний сайдын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 106 дугаар тушаал, 2017 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 53 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төв аймгийн Сэргэлэн суманд “Тэнүүн гэрэл” ХХК-ийн хэрэгжүүлж буй 15 МВт-ын нарны цахилгаан станц, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд “Наран тээг” ХХК-ийн хэрэгжүүлж буй 15 МВт-ын нарны цахилгаан станц, Дорноговь аймгийн Сайншанд суманд “Дезерт солар пауэр вуан” ХХК-ийн хэрэгжүүлж буй 30 МВт-ын нарны цахилгаан станцуудын сэргээгдэх эрчим хүчний барилга байгууламжид техникийн хяналт тавих гэрээний төсөл боловсруулах, хэлцэл хийх үүрэг бүхий ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр баталсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ерөнхий инженер	Д.Пүрэвсүрэн
Нарийн бичгийн дарга:	Салхины эрчим хүч, судалгаа тооцооны инженер	А.Кунся
Гишүүд:	Техник хяналт, үйлдвэрлэлийн хэлтсийн ахлах инженер	Г.Соронзонболд
	Ерөнхий нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч	Д.Дүүриймаа
	Хуульч	М.Ариунболд
	Хуульч	Г.Байгальмаа

2. Техникийн хяналт тавих ажлын гэрээний төслийг боловсруулан үр дүнтэй гэрээ байгуулан ажиллахыг ажлын хэсэг /Д.Пүрэвсүрэн/-т даалгасугай.

ЗАХИРАЛ



Ц.ЦЭРЭН